

Цэрэнхандын Буянхишиг^{1,✉}, Сарантуяагийн Далантай²

¹Өвөр Монголын Их Сургуулийн Монгол судлалын сургууль,
Их сургуулийн гудамж, Хөх хот, ӨМӨЗО, БНХАУ

²Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн Археологийн хүрээлэн,
Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайвны өргөн чөлөө,
Шинжлэх Ухааны Академийн хүрээлэнгүүдийн нэгдсэн I байр

**Кутлуг хааны цогцолбороос 2019 онд илрүүлсэн
зарим олдворын судалгаа**

Товчлол. Архангай аймгийн Хашаат сумын нутаг, Номгоны хөндийд орших Түрэгийн үед холбогдох дурсгалд 2019 онд ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн (Тухайн үеийн нэрээр) - Олон Улсын Түрэг Академийн хамтарсан шинжилгээний анги анхны малтлага судалгааг хийсэн билээ. Энд нийт 9 дурсгалыг дугаарлан бүртгэснээс 2 дугаартай дурсгалыг сонгон малтсан юм. Уг дурсгалд дөрвөлжин хэлбэртэй, дундаа нүхтэй засмал чулуу байсан бөгөөд энэ нь Билгэ хааны тахилын онгоны дөрвөлжин хавтан чулуутай ижилсэж байгаа нь үүнийг анх Түрэгийн хаад язгууртны онгон гэж үзэх гол үндэс боллоо. Энэхүү малтлагаас шинээр хос гүегтэй чулуун арслан, араатны (зээ бад) дүрст нүүр ваар зэрэг илэрсэн нь урьд өмнө олдож байгаагүй шинэ хэрэглэгдэхүүн болох юм. Номгоны хөндийн 2-р дурсгал болох шороон далан, зэл чулуу, тахилгын чулуу, арслан, хонь дүрст чулуун хөшөө бүхий уг цогцолборыг эртний Түрэгийн хожуу хаант улсын үед холбогдуулан үзэж байсан нь 2022 оны малтлага судалгааны үр дүнд Кутлуг хааны гэрэлт хөшөө илэрснээр багтагдсан билээ. Мөн дээрх олдворуудад Буддын шашны махбод орсон байгаа нь харагдах ба Түрэгийн хаад язгууртны дунд Буддын шашны нөлөө байсны нэг илрэл болж байна.

Түлхүүр үг: Номгоны хөндий, Түрэгийн язгууртны тахилын онгон, Тангийн соёл, чулуун арслан, нүүр ваар, зээ бад

Buyankhishig Tserenkhand^{1,✉}, Dalantai Sarantuya²

¹School of Mongolian Studies, Inner Mongolia University,
No:235 Daxue West road, Hohhot, Inner Mongolia, China

²Institute of Archaeology,
Mongolian Academy of Sciences Building-1,
Peace avenue, Ulaanbaatar-13330, Mongolia

An analysis of some artifacts discovered in 2019 from the Khutlug khagan's memorial complex

Summary. In 2019, a joint expedition of the Institute of History and Archaeology of the Mongolian Academy of Sciences and the International Turkic Academy excavated and studied a memorial complex related to the Turkic Period in the Nomgon Valley, Khashaat soum, Arkhangai aimag. 9 monuments from the Turkic Period were documented in this site, the monument with number 2 was selected to excavate. A square-shaped granite slab with a hole in the middle was found in this monument, which resembled the square slab of Bilge Khagan's memorial complex, so it was the main reason that it is considered as a memorial complex devoted to a Turkic Khagans or an aristocrats. There were discovered a lion statue with twin baby lions, and a type of roof ending tile with the form of a beast (zee bad), which are new findings never been found before. The monuments of Nomgon Valley complex consist of earthen ditch, balbal, stone structures of worship, stone statues of lions and sheep show that they belong to the Late Turkic Khaganate period, and it was also proven by the discovery of the Khutlug Khagan's stele during the excavation completed in 2022. These findings also show the presence of a Buddhist element, a sign of the influence of Buddhism among the Turkic Khagans and nobles.

Key words: *Nomgon Valley, Turkic aristocratic memorial complex, Tang culture, Stone lion, roof ending tile, zee bad*

Удиртгал

Түрэгийн үеийн хаад язгууртанд зориулсан тахилын онгон

Түрэгийн үед холбогдох археологийн дурсгалуудын дотор хаад ноёд, жирийн иргэдэд зориулсан тахил тайлгын онгон, тэдгээрийн бүрэлдэхүүнд багтах хүн чулуу, амьтны дүрст хөшөө, руни бичээст гэрэлт хөшөө, хавтан, зэл чулуу, уран барилгын холбогдолт дурсгал, хад чулуу болон бусад эд зүйлд сийлбэрлэн гаргасан тамга, их бага бичээс зэрэг зүйл ордог байна. Түрэгийн тахилын онгон нь түрэгүүдийн оршин суусан Евроазийн уудам нутгаар өргөн тархсан бөгөөд манай орны Дорнод, Сүхбаатарын талаас Алтайн их уулсыг хүртэлх нутагт элбэг олддог. Эл дурсгалууд нь нас барсан хүний язгуур угсаа, зэрэг дэвээс шалтгаалан их бага, янз бүрийн хэмжээтэйгээс гадна бүтэц зохион байгуулалтаараа ч өөр хоорондоо эрс ялгаатай. Манай орны нутгаас олддог буй Түрэгийн хаад язгууртны тахилын онгоны зах хязгаар нь зүүн зүгт Сүхбаатар аймгийн Түвшинширээ сум, баруун зүгт Завхан аймгийн Алдархаан сум, хойд зүгт Архангай аймгийн Цэцэрлэг сум, өмнө зүгт Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан сумын нутаг хүрч байна. [Мөнхтулга 2019: 128]

Язгууртны онгоныг үйлдэхдээ шороон хэрэм түүний дотор тахилын сүм байгуулж ар талд нь чулуун хашлага болон голдоо нүхтэй дөрвөлжин тахилын чулуу, гэрэлт хөшөө, хүн чулуу, чулуун арслан хонь зэргийг цогцлоодог бол зарим тохиолдолд зориудаар зассан шороон тавцан түүний дээр өнгөлж засаад хээ угалз гарган чимэглэсэн дөрвөн хавтангаар хашлага

босгож өмнө нь нэлээд бодтой уран хийцтэй хүн чулуу тавьж ихэвчлэн зүүн зүг чиглүүлсэн олон тооны зэл чулуу босгосон байдаг. Түрэгийн язгууртны тахилын онгоныг гадаад төрх, зохион байгуулалтаар нь В.Е.Войтов дөрвөн үндсэн төрөлд хуваан үзсэн байдаг [Войтов 1996: 70] бөгөөд сүүлийн үеийн судалгаагаар судлаач Р.Мөнхтулга нэмж хоёр төрлийг санал болгон нийт зургаан төрөлд хуваан үзжээ. [Мөнхтулга 2019: 42] XX зууны эхэн хагаст зарим судлаач тахилын онгон нь хүн оршуулсан булш бус, харин талийгаачийг дурсан санаж тахил үйлдэх ёслол шүтээний газар бололтой гэдэг санааг дэвшүүлсэн нь он удаан жилийн судалгааны явцад батлагдсаар олон судлаач дэмждэг болсон байна. [Мөнхтулга нар 2014: 10]

Судлагдсан байдал

Номгоны хөндийн цогцолбор дурсгалыг анх 2000 онд археологич Д.Баяр Билгэ хаан, Күлтигиний цогцолбор дурсгалыг малтан судлах явцдаа тухайн үед Хашаат сумын сургуулийн биеийн тамирын багш байсан н.Жанцангаар заалган очиж үзсэн байдаг¹.

2007 онд Нүүдлийн Соёл Иргэншлийг Судлах Олон Улсын Хүрээлэн, Монголын Үндэсний Музейн хамтарсан судалгааны анги дурсгалуудыг хэмжиж нийт 8 тахилын онгон илрүүлэн тодорхойлолт гар зургийг хийсэн байна. Тэд эдгээр дурсгалын бүтэц бүрэлдэхүүнд дүн шинжилгээ хийж тэдгээртэй ижил төстэй дурсгалуудыг

¹ Архангай аймгийн Хашаат сумын Засаг дарга Жанцангийн аман ярианы тэмдэглэл. // ШУА - ийн Археологийн Хүрээлэн, Олон улсын Түрэг Академийн хамтарсан судалгааны ангийн 2022 оны хээрийн шинжилгээний ажлын тайлан. ШУА-ийн гар бичмэлийн сан хөмрөг 2022 он

тоочин харьцуулж Түрэгийн язгууртны тахилын онгонтой нэгэн адил бөгөөд ойролцоо газар олноороо байрласан болохыг онцолжээ. [Очир нар 2009: 42]

Нүүдлийн Соёл Иргэншлийг Судлах Олон Улсын Хүрээлэн, Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейн хамтарсан судалгааны баг 2012 онд Номгоны хөндийд ажилласан байна. Ингэхдээ Бага Номгоны өвөрт орших тоногдсон хиргисүүрийн ойр орчмын 5 жижиг булшийг малтан судалсны үр дүнд хиргисүүрийн тахилын байгууламжийн зэрэгцээ Хүннү, Түрэгийн үед холбогдох жирийн иргэдийн булш буй хэмээн үзжээ. [Очир, Цэрэнбямба 2012: 22]

Судалгааны хэрэглэгдэхүүн

Дурсгалын тодорхойлолт

Уг дурсгал Архангай аймгийн Хашаат сумын нутаг Номгоны хөндийд оршино. 2019 онд ШУА - ийн Түүх, археологийн хүрээлэн - Олон улсын Түрэг Академийн хамтарсан шижилгээний анги эндээс 9 дурсгал илрүүлснээс II дурсгалыг сонгон малтсан байдаг. Тус малтлага судалгааны үр дүнд энэхүү онгон нь вааран дээвэртэй жижиг сүм, түүний гадуур тойрсон далантай, далангийн үүд зүүн зүг харсан байрлалтай. Гол сүмийн хойд талд 220 x 220 см хэмжээтэй, 33 см зузаан дөрвөлжин хэлбэртэй, дундаа 80 см голчтой нүх бүхий тахилын чулуу байх бөгөөд энэ нь Билгэ хааны тахилын онгоны голдоо нүхтэй тахилын чулуутай ижилсэж байна. Билгэ хааны тахилын онгоноос голдоо нүхтэй тахилын дөрвөлжин чулууны зэрэгцээ 4 хавтант хашлага чулуу олдсон нь Түрэгийн тахил тайлгын байгууламжийн судалгаанд цоо шинэ зүйл боллоо [Баяр нар 2003: 81] гэжээ. Номгон II голдоо нүхтэй тахилын чулууны баруун хойд талд байх хонхор хэсгийн хаяагаар хавтан чулууны 3 ш жижиг хагархай олдсон нь Күлтегин, Билгэ хааны онгонтой ижилсэх бололтой. Мөн голдоо нүхтэй тахилын чулууг 4 хавтант хашлага чулууны дээрээс таглаж хийсэн бөгөөд энэ нь Баянхонгор аймгийн Галуут сумын нутаг Олон Нуурын хөндийд буй тахилын онгонтой ижил ажээ. [Баяр 2008: 56] Гол сүмийн өмнө талд, мэлхий суурьтай гэрэлт хөшөө, хүн чулууны ёзоор хэсгийн хугархай илэрснээс гадна толгой нь хугарч унасан хонины чулуун хөшөөний нэг нь ил харагдана. Шороон далангийн гадна талаар 1.8 – 2 м өргөн, 1.4 м гүнтэй сорилын суваг татахад баруун зүүн өмнө талаар тойрсон зэл чулуу мэт чулуун хүрээ байх бөгөөд мэлхий чулуун суурьтай гэрэлт хөшөөний урд талаас наран ургах зүг буюу зүүн зүгт 48 зэл чулуу мэдэгдээд байна. [Энхтөр нар 2022: 73]

Хэлэлцүүлэг

Шинээр илэрсэн олдворууд

Чулуун арслан. Арсланг саарал өнгийн боржин чулуугаар суугаа байдалтай дүрсэлжээ. Арслангийн толгойг дүрслэхдээ чихийг хойш хулмайлган, амаа ангайсан байдалтай, хоншоорын хэсэг болон доод эрүү бахим бүдүүн, хоёр нүдийг дүрлэгэр томоор гаргасан байх бөгөөд үзүүр хэсэгтээ нарийссан урт сахалтай. Хүзүүндээ олон салаалж эргэсэн зогдортой. Цээжин хэсгийг урагш төвийлгөн дүрсэлсэн бөгөөд хойд хоёр хөл дээрээ оцойн суухдаа сүүлээ ар зоон дээгүүр давуулан агссан байна. Арслангийн хэвлийн харалдаа урагш болон ар тийш цавь руу нь шургасан хоёр гүегийг сийлсэн ба арслан баруун урд хөлөө дээш өргөн сарвуугаар нугалж хоёр гүегээ өөр рүүгээ шахсан мэт байдалтайгаар дүрсэлжээ. Гүегүүд бие бие дээрээ давхралдан тоглож буй мэт харагдах бөгөөд эхний гүег арслангийн хэвлийд наалдан шургасан ба толгойг эхийн урд хоёр хөлийн завсраар гаргаж тонгойлгон дүрсэлсэн бол удаах гүегийг эхний гүегийн толгой дээгүүр даван гарч эхийнхээ цавины баруун талаар цухуйн гарсан байдалтай, урд хоёр хөл болон толгойг мэдэгдэхүйц тодоор сийлбэрлэсэн байна.

Урьд өмнө илэрч олдсон арслангийн хөшөөнд ихэвчлэн дангаараа суугаа арслан дүрслэгдсэн байдаг бөгөөд харин бидний өмнөх жилийн судалгаагаар Шивээт Улааны дурсгалаас нэг гүегтэй чулуун арслан 2 илэрсэн билээ. [Цэвээндорж нар 2018: 128] Чулуун арслан илэрсэн дурсгалуудыг тойм байдлаар авч үзвэл Өнгөт, Мухар, Хөшөө Цайдам 1-д тус бүр 1, Хөшөө Цайдам 2, Арвайхээрийн музей, Эрдэнэ мандал, Их Хөшөөтөд тус бүр 2, Шатар Чулуунд 2 мөн 2 сийлбэр, Шивээт Улаанд 8, Номгонд 4 гэх мэт албан бус тоогоор 20 гаруй илрээд байна. Манай улсын нутгаас илэрч буй чулуун арслангийн хөшөө хамгийн эртдээ Түрэгийн үед холбогдох бөгөөд түүнээс өмнөх нүүдэлчдийн дунд чулуун арслан болон амьтны дүрс сийлж босгох соёл байсангүй бололтой. Тэгвэл энэ соёл чухам хаанаас нүүдэлчдийн дунд нэвтрэн орсон нь сонирхолтой юм. Хятадын нутгаас арслангийн хөшөө нэлээд олддог бөгөөд зүүн, баруун Хань улсын (НТ 23-220) үеэс эхлэн Таван улс арван ханлигийн үе (НТ 907-960) хүртэл хийц төрх нь хувьссан байна. Умард Вэй улсын үед (НТ 386-534 он) хадан ханан дээрх Буддын шашны сийлбэрийн урлагаас чулуун арслангийн дүр дүрслэлд шинэ махбод орж иржээ. Энэ үед зогсоо болон гүйж буй хуучин дүрслэлээс хойд хоёр хөл дээрээ оцойн сууж буй дүрслэл рүү аажмаар шилжжээ. Үүнээс хойш Тан улсын үеийн урлагийн онцлогийг харуулсан арслан урлах шилжилтийн үе буюу

чулуун арслан сийлбэрийн ид цэцэглэлтийн үе эхэлсэн бөгөөд одоогийн ерөнхий хэлбэр дүрс энэ үед бий болжээ. Хятадын түүх бичлэгээр бол Тан улс нь үе залгамжилсан нийт 21 хаантай байсан бөгөөд тэдгээрээс 18 хааны онгонд чулуун арслангийн сийлбэр байдаг аж. Эдгээр чулуун арслангууд янз бүрийн хэлбэр загвартай боловч бүгд биерхүү том байдлаараа тэр үеийн гоо зүйн ерөнхий ойлголтыг тусгасан байдаг. [夏子婕 2014: 21] Тангийн дунд үед арслангийн толгой нь томорч хүзүүний зогдрын дүрслэл үзүүр рүүгээ дугуйран мушгирч эхэлсэн байна.

Тангийн үеийн язгууртны булшны үүдэнд орших чулуун арслангийн хэв шинж нь талийгаачийн зэрэг дэвээс хамаарч өөр өөр байна. Жишээ нь хамгийн өндөр зэрэглэлийн их хааны онгоны үүдэнд голдуу 2.5-3 м өндөр байхад хоёрдугаар зэргийн бунхан нь ханхүүд эсвэл талийгаачийн амьд ахуйдаа байгуулсан гавьяаг үнэлэн нөхөж байгуулсан бунханд, арслангийн тоо нь ижил боловч өндрийн хэмжээ 1.2-2.2 м болж багасдаг. Харин гуравдугаар зэргийн буюу ханхүү, гүнжийн бунхны өмнө арслан бус, бар болон хонины хөшөөг тавьдаг. Иймээс талийгаачийн зэрэг дэвээс хамаарч үүдэнд тавих арслангийн дүр хоорондоо адилгүй байна. [贾璞 2017: 110] Чулуун арслан нь талийгаачийн сүнсэнд зориулан гурван ертөнцийг холбон хамгаалагч болох үүрэгтэй байжээ. Чулуун арсланг тахилын онгоны хэрэм суваг хоёрын дунд хаалгыг сахиулан тавьдаг ба дундад Азийн олон улс ардын үлгэр домогт гардагчлан үхэгсдийн ертөнцийг бусад муу зүйлээс хамгаалж үүдэнд нь сахиж байхыг бэлгэдсэн байна. [В.Е.Войтов 1996: 97]

Чулуун арслан нь хэлбэр хийцийн хувьд бодит арслангаас бага зэргийн ялгаатай байдаг. Түрэгийн чулуун арслан амаа ангайж шүдээ ярзайлгасан төрхтэй бөгөөд цээжээ төвийлгөн суух нь их л сүр хүчтэй харагдах ажээ. Учир нь талийгаачийн сүнс сүлдийг элдэв муу ёрын зүйлсээс хамгаалан амар амгалан байлгах гэсэн санаа бололтой. Арсланг дүрслэхдээ эр эмийг ялган дүрслэх нь маш чухал байсан бололтой. Зарим арсланг эр бэлэг эрхтэнтэйгээр дүрсэлдэг бол заримдаа сүүлний байр байдлаар нь ялган дүрсэлдэг. Жишээ нь эмэгчин арсланг сүүлийг нь салтаагаар оруулан цавины дээгүүр цухуйлган гаргадаг бол эрэгчин арсланг нурууны дээр агссан байдлаар дүрсэлдэг ажээ. Тиймээс Номгоны 2-р дурсгалын арслан бол эр арслан болох юм. Уг арслангийн дүрс нь өмнө олдсон бусад чулуун арслангуудаас агуулгын хувьд өөр бөгөөд түүнтэй хоёр гүег хамт дүрсэлсэн нь хааны сүнс сүлдийг үеийн үед улиран хамгаалах гэсэн санаа бололтой. Мөн Кулуг хаан нүүдэлчдийн дунд зүүн Түрэгийн хаант улсыг байгуулсан нь тухайн цаг үеийнхээ амар тайван

байдлын үүднээс, энх цагийг давхар бэлгэдэн, хос гүегийг тоглуулан дүрсэлсэн бололтой.

Хонины хөшөө. Бүдүүн ширхэгтэй шаргал боржин чулуугаар хэвтэж буй хонийг дүрсэлсэн бөгөөд толгой хэсгийг ташуу хагалсан байна. Хөшөө чулууны хоёр хажууд хэлбэр дүрс нь тодорхойгүй угалзарсан бүдэг сийлбэр мэдэгдэнэ. Энэ нь хонины хөлийг сийлсэн нь он цагийн эрхэнд бүдгэрч мэдэгдэх төдий болсон гэлтэй. Хөшөөний зүүн хэсэг нь бага зэргийн хотгор хэлбэртэй. Сүүлний дүрслэл мэдэгдэхгүй болжээ.

Эндээс илэрсэн хоёр хонины хөшөө нь чулууны бүтэц болоод хэлбэрийн хувьд ижил төрхтэй бөгөөд хоёул толгой нь хугарч унасан байдалтай. Харин шинээр олдсон хөшөөний хажуугаас боржин чулууны жижиг хугархай олдсон нь уг хонины хөшөөний толгойн хугархайн нэг хэсэг бололтой. Үүнийг хонины хөшөөний нэг хэсэг мөн гэж үзээд, хэлбэр дүрсийг нь ажиглан харвал угалзарсан эвэртэй хуцын дүрслэл байх боломжтой юм. Хонь бол эд баялгийг бэлгэддэг бөгөөд том хэмжээтэй тарганаар дүрслэх ба уг эвэртэй амьтны дүрийг үүдэнд тавьдаг нь арслангийн дүртэй адилаар хамгаалах үүрэгтэй байжээ. Энэ шинж мөн Тангийн гүнжийн бунхны үүдэнд байдагтай адил ба Билгэ хааны онгоны малтлагаас хэрмийн үүдэнд анхны байрлалаараа илэрч байжээ. [Баяр нар 2003: 77] Харин Түрэгийн язгууртанд арслан хонь зэргийг хамт нэг онгонд цогцоор байрлуулсан хэлбэр нь язгууртнуудын эрх ямба, зэрэг зиндаа, сүр хүчийг бэлгэдэн талийгаач хааныг бусдад бахдан бишрүүлэх санаанаас үүдэлтэй бололтой.

Нүүр ваар. Нүүр ваар нь дээд хэсгээрээ хугарсан ба 14 см голчтой, 1.2 см зузаан, саарал өнгийн нарийн ширхэгтэй шавраар хивэнд цутгаж хийжээ. Захын хүрээний өргөн 2 см, түүний дотор хүрээг тойруулан дугуй хэлбэрийн товруун чимэглэл 19 - ийг эгнүүлсэн байна. Араатан (зээ бад)-ыг дүрслэхдээ духан дээрээ 3 долгиотсон үрчлээтэй, доод талд нь хоорондоо нийлсэн мэт харагдах, хамрын дээд хэсэгтэй нийлсэн урт хөмсөгтэй. Том жижиг бүлтгэр хоёр нүдтэй, өргөн угалзтай том хамартай, хацар шанааны ясыг төвгөр том дүрсэлжээ. Мөн нимгэн урт сунасан уруултай, завжны хоёр талын хацарт тус бүр хоёр үрчлээ гаргасан нь инээмсэглэж буй хүн мэт харагдана. Уруулын дотор талд хоорондоо зөрсөн 4 соёо цухуйх бөгөөд баруун талын хоёр соёо нь хоорондоо ялимгүй зайтай. Хоёр талаасаа түрж гарч ирсэн хоёр төвгөртэй эрүүний голд хонхор дүрсэлжээ. Ар талын хэсэгт тал ирмэгийг зураас таган арзайлгаж өгсөн нь нөмрөг ваартай залгагдах хэсэг бөгөөд төв хэсэгтээ жижиг дөрвөлжин модоор дарсан бололтой ором байсан нь хивэнд цутгах үед үүссэн бололтой.

Зээ бад хэмээх үгийг орчуулбал “үзүүр бадам” гэсэн төвөд үг бөгөөд үзүүрийн бадамлянхуа гэсэн утгатай ажээ. Манайд яг хэдийд орж ирсэн талаар бичиж тэмдэглэсэн зүйл байхгүй ба сүм хийдийн хаалга үүд, дээврийн нүүр ваарт дүрсэлдэг байжээ. Манай улсын нутаг дэвсгэрээс араатан (зээ бадын)-ы дүрслэлтэй нүүр ваар эртний Уйгур, Хятан, Их Монгол улсын үеийн хот суурин, барилгын ор үлдцээс илэрдэг билээ. Мөн БНХАУ, ОХУ-ын Сибирь, Алс Дорнодын газар нутаг дахь эртний хот суурины дурсгалаас олдсон нүүр ваар дээрх хээ, чимэглэл дүрс нь Хятадын эртний улсуудын хот сууринаас гарсантай ижил хэв загвартай байдгаараа түүхэн он цагийг тодорхойлох нэгэн чухал хэрэглэгдэхүүн болж буй юм. [Дашдорж 2014: 68]

Урьд өмнө манай нутгаас илэрч байсан араатны (зээ бад) дүрстэй нүүр ваарыг судлаачид Хятадын эртний домгийн амьтадтай адилтган үздэг бөгөөд энэ төрлийн амьтан олон янз байдаг билээ. Эдгээр амьтдын дүрсийг хооронд нь ялгаж салгаж ойлгох, тэдгээрийн зүй ёсны хэрэглээг олж мэдэх зайлшгүй шаардлагатайг Номгон II-оос илэрсэн нүүр ваар харуулж байна. Эртний Хятадын барилгын чимэглэлд энэхүү домгийн амьтан (араатан)-ы дүрслэл элбэг байдаг бөгөөд хамгийн анх хүрэл зэвсгийн үеийн Шан (商, Shāng), Чжоу (周, Zhōu) улсын хотын туураас Таотие (饕餮, tāotiè) хэмээх домгийн амьтнаар чимэглэсэн нүүр ваар илэрчээ. [王进华 2016: 373] Таотиет зарим судлаачид луугийн тавдугаар хүү гэдэг бол зарим нь луугийн хүү биш хэмээн үгүйсгэдэг. Тан улсын домогт луу есөн хүүхэдтэй бөгөөд түүний гуравдугаар хүүг Биань (狴犴, Bì àn) гэдэг. Биань бол Хятадын домогт шударга ёсыг баримтлагч хэмээн гардаг. Эртний Хятадын барилгын соёлд уг хоёр араатныг голчлон барилгын дээврийн чимэглэлд дүрсэлдэг байжээ. Мөн үүнээс гадна арслан дүртэй нүүр ваар ч хийдэг байж. Буддын шашны ёсонд арсланг хамгаалагч араатан хэмээн үздэг бөгөөд нүүр ваар дээр анх Умард Вэй улсын үеэс дүрсэлж эхэлсэн бололтой. Түүрү Тангийн үеийн араатны дүрст нүүр ваарын захаар дугуй хүрээтэй дусал хээ байдаг ба энэ нь хожуу Тангийн үед хөгжиж араатны дүрст нүүр ваарын тойргийн хэмжээ томорч хээ чимэглэл нь илүү тод товгор болж зогдор сахал зэрэг нь нийлж эхэлсэн байна. Нүүр ваарын голч 13-16 см орчим хэмжээтэй, гадна хүрээний дусал хээ давхар бөгөөд ирмэг нь нүүр хэсгээсээ өндөр мөн мөлхөө ургамлын загвартай мушгирсан зураасаар араатны дүрсийг гаргасан байдаг. [王进华 2016: 378]

Түрэгийн тахилын онгоны хэрэм болон гол сүмийн орчмоос илэрдэг нүүр ваарын хээг голчлон Бадамлянхуа, Цээнэ зэрэг цэцгээр чимэглэсэн байдаг [The project 2005: 180] бөгөөд

энэ дүрс нь ариун цэвэр, эрхэмсэг тайван байдлыг бэлгэддэг байна. Харин энэ удаад араатны толгойн дүрсээр чимэглэсэн нүүр ваар олдсон нь анхны тохиолдол бөгөөд барилгын дээврийн эдгээр гурван төрлийн нүүр ваарын чимэглэл нь Тан улсын үед хүчтэй дэлгэрсэн байсан ба нүүр ваар хийх чимэглэлийн соёл хөгжихийнхөө хэрээр шинэ шатанд гарч Дорно дахин болон Төв Азид ихээр тархжээ. [Киселев 1959: 165] Түүхийн ямар ч үед хөрш зэргэлдээ улс орнуудын харилцаа холбоо, соёл харилцан бие биедээ нөлөөлсөн байдаг нь археологийн биет хэрэглэгдэхүүнээс тодорхой харагддагийн нэгэн тод жишээ үүнээс харагдаж байна. Харин тухайн соёлыг хүлээж авахдаа өөрсдийн үзэл суртлыг тусган шинэ өнгө аястай болгосныг уг тахилын онгоноос илэрсэн нүүр ваар харуулж байна. Учир нь Тангийн үеийн нүүр ваар дээрх араатны дүрслэл арслантай илүү төстэй бол Номгон 2 - ын тахилын онгоны гол сүмийн нүүр ваар хүний нүүрний төрхтэй илүү төстэй мэт харагдах бөгөөд цаагуураа араатан (арслан) дүрсэлсэн бололтой юм. Үүнтэй ижил төрлийн нүүр ваар өмнө нь манай орны нутгаас Хятан улсын үеийн Чинтолгойн балгаснаас олдсон ба энэ нь хотын төв хэсэгт орших нэгэн барилгын туурийг малтах явцад 2 ш илэрчээ. Эхний нүүр ваарын дээр амьтны нүүрийг хоёр эгнээ зураасаар тойруулан, тэдний дундуур товгор чимэглэл шигтгэж өгчээ. Харин хоёр дахь нүүр ваарын шулуун зураасан чимэглэлийн дотуур товгор хээ тавьсан бөгөөд гаднах ирмэгээр өөр давхар чимэглэл байхгүй гэжээ. [Очир нар 2008: 22] Мөн хоёр дахь хэлбэртэй ижил нүүр ваар Чинтолгойн хэрмийн зүүн хойд хаалганы малтлага судалгаагаар илэрч байжээ. [Энхтөр нар 2013: 217] Ийнхүү хожим Хятаны үеэс араатны дүрст нүүр ваар голчлон хийж эхэлсэн нь Буддын шашны нөлөө гүнзгий орсны илрэл бололтой.

Үүнээс гадна Түрэгийн үед тахилын зан үйл буюу талийгаачид өргөл өргөх ёслолыг олон удаа давтан үйлддэг байсныг батлах нэгэн зүйл нь тахилын онгон байгуулдаг байсан заншил юм. Тахилын онгон байгуулах нь нүүдэлчдийн хувьд нэн төвөгтэй нүсэр бүтээн байгуулах ажил болж байсан нь маргаангүй юм. [Мөнхтулга 2020: 129] Иймээс суурин соёл иргэншлийн эртний улбаатай Тан улсын барилга архитектурын шийдлийг шууд болон дам авч ашиглаж байсан нь барилгын хийц чимэглэлийн дүр төрхөөс харагдана. Үүнээс үзэхэд худалдаачид, гар урчуудтай хамт тусгайлан барилга архитектурт гаршсан дархчид торгоны замаар ирж алба өргөн суудаг байсан бололтой. Монгол оронд буй эртний хотуудыг байгуулахад, дайнд олзлогдож ирсэн буюу нүүдэлчдэд дагаж орсон хятад хүмүүсийн үүрэг оролцоо нэлээд байсан нь чулуун хөшөө, барилгын хэрэглэгдэхүүн,

гоёл чимэглэл зэрэг эд өлгийн дурсгалаас мэдэгддэг. Харин согдууд хэдийнээс эхлэн Монгол нутагт суурьшиж хот орон байгуулах, шашин ном дэлгэрүүлэх болсон тухай сонирхолтой асуудлыг нягтлан үзэх шаардлагатай юм. [Баяр 2013: 374] Монгол нутагт байсан эртний нүүдэлчдийн улс аймгууд Дундад Азийн орнуудтай соёлын харилцаатай байсан нь бас тодорхой хэмжээгээр харагдаж байна.

Дүгнэлт

Номгоны хөндийд орших Номгон 2 цогцолбор дурсгал нь Хөшөө Цайдам, Тоньюкук, Шатар Чулуу, Цагаан овоо зэрэг дурсгалуудтай ижилсэж байна. Тэдгээр дурсгалуудын тахилын онгоныг цогцлоон бүрдүүлж буй махбод нь Түрэгийн хааны ургийн язгууртанд зориулсан болохыг илтгэж буй юм. Нарийн хийц загвартай ихэс дээдсийн онгон шүтээнийг цогцлоон босгоход эрх мэдэл зэрэг дэвээс хамаарч хүн хүнд зориулагдсан онгон нь өөр хоорондоо адилгүй байжээ. В.Е.Войтов энэ талаар дурдан хэлбэр хэмжээ, төрлөөр нь үндсэн 4 төрөлд хуваан авч үзсэн байдаг. Номгон II-ын зэл чулуу, тахилгын чулуун байгууламж, арслан дүрст чулуун хөшөө бүхий цогцолбор дурсгал нь Түрэгийн хожуу хаант улсыг байгуулсан Кутлуг хааны цогцолбор болох нь гэрэлт хөшөө илэрснээр батлагдсан билээ. Мөн эндээс олдсон тахилын чулуу, хөшөө чулуу зэрэг нь хэмжээгээр жижиг, бүрдэл хэсгүүд өөр боловч бүтцийн хувьд Билгэ хаан, Күлтигин нарын тахилын онгоны нэгэн адил хэв загвартай билээ. Түрэгийн хаад язгууртны тахилын онгонд уламжлал болгон дүрсэлж хийдэг хийц хэлбэр бүхий арслан, хүн чулуун хөшөөд нь хэдийгээр зарим нь эвдэрч үгүй болсон ч малтлагаар илэрсэн суваг, далан, сүмийн туурь, гэрэлт хөшөө, тахилын байгууламжийг тойруулсан суваг, зэл чулууд нь үндсэн байрлалаа хадгалан үлдсэн байдаг бөгөөд тодорхой нэгэн үеэс энэ төрлийн тахилын онгоныг үйлдэх дэг жаяг бүрэлдэн тогтсон бололтой.

Уг тахилын онгоны эхний удаагийн сорьц малтлагаас олон шинэ содон олдвор илэрсний нэг нь хос гүегтэй арслан болно. Үүнтэй төстэй боловч нэг гүегтэй арслан Шивээт улааны цогцолбор дурсгалаас олдсон билээ. Мөн нүүр ваарын араатан (зээ бадын)-ы дүрс нь урьд өмнө манай орны нутгаас илэрч байгаагүй өвөрмөц төрхтэй бөгөөд энэ төрлийн дүрслэлтэй ваарын хамгийн эртнийх нь ийнхүү Зүүн Түрэгийн хаант улсыг байгуулсан Кутлуг хааны онгоноос анх удаа олдож байна. дагасан соёлын харилцаа холбоо ойр байсныг илтгэх бөгөөд энэ тухай сурвалжийн мэдээ ч байдаг билээ. Мөн дээрх олдворуудад Буддын шашны махбод байгаа нь илэрхий харагдах ба энэ

нь эртний Түрэгийн хаад язгууртны дунд Буддын шашны нөлөө байсны нэг илрэл болж байна.

Хөрш орны соёлыг богинохон хугацаанд тусгаж авч буй явдал нь тэдний оюун санаа ертөнцийг үзэх үзэл тийм ч хол зөрүүгүй байсныг харуулна. Ер нь аль ч нийгмийн үед бусдын ид хөгжиж буй соёлыг сонирхон даган дуурайх гэсэн хүсэл эрмэлзэл байдаг учир тухайн соёл тэр чинээгээрээ хурдацтай тархахад түлхэц болдог. Харин тархаж буй газрынхаа нийгэм соёлд хэрхэн идээшиж дасан зохицохоос хамаарч соёлын насжилт нь янз бүр байдаг. Иймээс тухайн соёлыг хүлээж авахдаа нүүдэлчид өөрсдийн үзэл суртлын онцлогийг тусган, өөрийн гэсэн өвөрмөц дүр төрхийг бий болгодог байсныг энэхүү тахилын онгоноос олдсон чулуун арслан, нүүр ваар тод харуулж байна.

Өгүүлэл хүлээн авсан: 2023 оны 03 сарын 31

Өгүүлэл засварласан: 2023 оны 04 сарын 17

Өгүүлэл хэвлэгдсэн: 2023 оны 6 сарын 30

Ном зүй

Баяр нар 2003 – Д.Баяр, Ч.Амартүвшин, А.Энхтөр, Ж.Гэрэлбадрах. Билгэ хааны тахилын онгоны судалгаа. // Археологийн судлал. Том (I) XXI. Fasc 8. УБ. Тал 75 -.83

Баяр 2013 – Д.Баяр. Уйгурын Байбалык хотын тухай тэмдэглэл. Монголын дундад зууны археологийн судалгаа. 2-р боть. УБ. Тал 374

Баяр 2008 – Д.Баяр. Нүүдэлчдийн түүх-соёлын нэгэн шинэ дурсгал. // Түүхийн судлал. Том XXX-VIII. Fasc 3. УБ. Тал 55 -.58

Войтов 1996 – В.Е.Войтов. Древнетюркский пантеон и модель мироздания в культово-поминальных памятниках Монголии VI-VIII вв. Москва. 7-130 с

Дашдорж 2014 – Б.Дашдорж. Хятаны барилгын нүүр ваарын тухайд (Чинтолгойн жишээн дээр). Хятаны өв соёл. УБ. Тал 66 - 72

Киселев 1959 – С.В.Киселев. Из истории китайской черепиц (В связи с изучением древних городов Монголии, Сибири и Дальнего Востока). // Советская археология. № 3. Москва. 159 – 178 с

Мөнхтулга 2019 – Р.Мөнхтулга. Эртний түрэгийн язгууртны тахилын онгоны судалгааны зарим асуудлууд. Докторын зэрэг горилсон бүтээл. УБ. Тал. 42

Мөнхтулга нар 2014 – Р.Мөнхтулга, Ц.Болорбат, А.Энхтөр, Ц.Буянхишиг. Донгойн Ширээн дурсгал. УБ. Тал 10 Эдгээр олдворууд нь Тангийн хаадын онгоныхтой илүү төслөг байгаа нь Торгон зам

Очир нар 2008 – А.Очир, Н.Н.Крадин, А.Л.Ивлиев, С.В.Данилов, Л.Эрдэнэболд, Ю.Г.Никитин, А.Энхтөр, Б.Анхбаяр, Г.Батболд. Чинтолгой балгасны судалгаа (Археологические Исследования Городище Чинтолгой). УБ. Тал. 21-22

Очир нар 2009 – А.Очир, Ц.Одбаатар, Л.Эрдэнэболд, Б.Анхбаяр. Номгоны түрэг дурсгалууд. Nomadic Studies. УБ. Тал. 35-47

Очир, Цэрэнбямба 2012 – А.Очир, Х.Цэрэнбямба. Архангай аймгийн Хашаат сумын нутагт орших Номгоны хөндийд явуулсан археологийн малтлага судалгааны ангийн тайлан. УБ. Тал. 3-22

Цэвээндорж нар 2018 – Д.Цэвээндорж, А.Энхтөр, Б.Напил, С.Далантай, Н.Богэнбаев, Ц.Буянхишиг. Монгол улс - Олон улсын түрэг академийн хамтарсан “Шивээт улаан” төслийн 2018 оны хээрийн шинжилгээний ажлын тайлан. УБ. Тал. 11-20

Энхтөр нар 2013. – А.Энхтөр, Г.Батболд, Ц.Буянхишиг, Ё.Сэндай, И.Үсүки, К.Кияама. Чинтолгойн хэрмийн зүүн хойд хаалганы малтлага судалгаа. // Археологийн судлал. Том XXXIII. Fasc, 14. УБ. Тал 216-225.

Энхтөр нар 2022. – А.Энхтөр, К.Дархан, Б.Напил, Б.Нурболат, Ц.Буянхишиг, Г.Батболд, С.Далантай. Кутлуг хааны тахилын онгон цогцолбор, гэрэлт хөшөө. // Археологийн судлал. Том XLI. fasc 7. УБ. Тал 69-86.

The project 2005 – The project of the Turkish monuments in Mongolia, 2003 studies. Ankara. P 153 - 186


贾璞 2017 – 贾璞。【中国历代石狮造型艺术的演变及文化内涵】河南社会科学, 第25卷, 郑州。

王进华 2016 – 王进华。【唐代瓦当纹饰研究】唐史论丛: 第二十三辑。第371 – 380卷


夏子婕 2014 – 夏子婕。【两汉至唐宋陵墓建筑中石雕狮子艺术造型的演变】硕士研究生学位论文, 江西师范大学。第13 – 21卷




Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.




Зураг 1. Дурсгалт газрын байршил зурга




Зураг 2. Номгоны дурсгалууд, агаарын зураг



Зураг 3. Номгон II



Зураг 4. Номгон II, 2019 он малтсан талбайн тойм дэвсгэр зураг



Зураг 5. Номгон II-оос шинээр олдсон арслангийн зураг



Зураг 6. Тангийн чулуун арслан.
(Ёнканы бунхан)



Зураг 7. Хэнань-ий луут хаалганы
чулуун агуйн ханын сийлбэр



Зураг 8. Номгоноос илэрсэн нүүр
ваарын хуулга



Зураг 9. Тангийн нүүр ваар



Зураг 10. Чин толгойгоос илэрсэн
нүүр ваар